



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Сэлэнгэ аймгийн Аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны
төлөвлөгөөний дагуу хийсэн аудитын тайлан

СЭЛЭНГЭ АЙМГИЙН 2016 ОНЫ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Ерөнхий дүгнэлт:

*Төсвийн төслийг бодитоор боловсруулаагүй, зарим орлогыг үндэслэлгүйгээр
өсгөж төлөвлөснөөс тайлант онд аймаг, сумдын төсөвт 2-4 удаагийн
тодотгол хийгдсэн байна.*

Сүхбаатар сум 2017 он

Тайланг бэлтгэсэн: ҮАГ-ын харьяа Сэлэнгэ аймгийн Аудитын газар Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа Аудитын менежер Б.Батмөнх Ахлах аудитор Б.Наранчимэг Аудитор: Ц.Отгонбаяр Шинжээч: С.Баасансүрэн 2017 оны 04 сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70362442, 70363036 дугаарын утас, 70363040 дугаарын факсаар харилцана уу. ХАЯГ:Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, аймгийн ЗДТГ-ын байрны өргөтгөлд	ТАЙЛАНГИЙН АГУУЛГА Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Үндсэн мэдээлэл БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨСӨН ҮҮ ? 1.1 Орон нутгийн төсвийн орлогыг холбогдох хууль эрхийн актуудад нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх 1.2 Орон нутгийн төсвийн зарлагыг холбогдох хууль эрхийн актуудад нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх 1.3 Орон нутгийн төсвийн орлого, зарлагыг үндэслэл муутай төлөвлөснөөс төсвийн жилийн дундуур тодотгол хийгдсэн эсэх 1.4 Орон нутгийн төсвийн тэнцлийг алдагдалтай төлөвлөсөн эсэх, нөхөх эх үүсвэрийг бодитой тооцсон эсэх БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛСЭН ҮҮ ? 2.1 Татварын ба татварын бус орлогын төлөвлөгөөг биелүүлэх нөөц боломжийг бүрэн ашигласан эсэх 2.2 Төсөвт байгууллагууд болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн орлого нэмэгдүүлэх нөөц боломж байсан эсэх 2.3 Орон нутгийн төсөвт төвлөрөх орлогыг холбогдох хууль,эрхийн актуудад нийцүүлэн бүрэн төвлөрүүлсэн эсэх БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ БОДИТОЙ БАЙНА УУ ? 3.1 Төсвийн зарлагын гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан бодитой эсэх 3.2 Тусгай сан, хөрөнгө оруулалтын батлагдсан зардлыг хууль эрхийн актын хүрээнд зарцуулсан эсэх 3.3 УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолын хүрээнд төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх <i>/гадаад томилолт, төвлөрсөн арга хэмжээ, урсгал засвар, машин техник худалдан авалт/</i> 3.4 Төсвийн нэмэлт санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх Илрүүлсэн зөрчил Аудитын дүгнэлт Зөвлөмж
--	--

Товчилсон үгийн тайлбар

БСШУС	Боловсрол соёл, шинжлэх ухааны сайд
БХБС	Барилга хот, байгуулалтын сайд
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	иргэдийн Төлөөлөгчийн Хурал
ИХШХГ	Иргэний харьяат шилжилт хөдөлгөөний газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХАХНХС	Хүн ам хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМС	Эрүүл мэндийн сайд

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудитын нэр:

Сэлэнгэ аймгийн 2016 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэл

2. Аудитын код:

СЭЛ-2017/01-СТА-ТЕЗ

3. Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Аудитын газар хийж гүйцэтгэв.

4. Аудитын зорилт:

Сэлэнгэ аймгийн 2016 оны төсвийн төлөвлөгөөг үндэслэлтэй хийж, гүйцэтгэлийг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг шалган, дүгнэлт, зөвлөмж боловруулан, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт оршлоо.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөсөн үү?
- Орон нутгийн төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн үү?
- Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл бодитой байна уу?

5. Аудитын хамрах хүрээ:

Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг, орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт, төсвийн орлого, зарлагыг баталсан аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, ТЕЗ-ийн 2016 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэлээ.

6. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулан аудитын дүгнэлт, зөвлөмж, боловсруулав.

7. Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Төсвийн тухай хууль, 2016 оны Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Татварын багц хуулиуд, холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

8. Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Сэлэнгэ аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Б.Наранчимэг, аудитор Ц.Отгонбаяр, шинжээч С.Баасансүрэн нар 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 04 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

Үндсэн мэдээлэл

Сэлэнгэ аймгийн 2016 оны төсвийн орлого нь татварын ба татварын бус орлого, улсын төсвийн санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг, төсөвт байгууллагуудын өөрийн орлогоос бүрдсэн бөгөөд уг эх үүсвэрээр орон нутгийн төсвийн 104, тусгай шилжүүлгийн 131 байгууллага, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ болон ОНХС зэрэг тусгай сангуудыг санхүүжүүлсэн байна.

2016 онд Монгол Улсын төсөвт 2 удаа тодотгол хийгдсэнтэй холбоотойгоор аймгийн төсөвт 3 удаа, сумдын төсөвт тус бүр 2-4 удаа тодотгол хийж, нийт орлогыг 69,341.8 сая төгрөгөөр, нийт зарлагыг 77,218.4 сая төгрөгөөр төлөвлөж баталсан байна.

Аймгийн нийт төсвийг 7,876.6 сая төгрөгийн алдагдалтай баталсан мэт харагдаж байгаа нь мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 1,900.4 сая төгрөгийг тодотгоогүй, төсөл сангийн 5,976.2 сая төгрөгийн зардлын эх үүсвэрийг төлөвлөлтөд тусгаагүйгээс шалтгаалжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн нийт орлого 107.6 хувь, нийт зарлага 91.1 хувийн биелэлттэй тайлагнагдсан байна.

Санхүүжүүлэх үүсвэр бүрдээгүйгээс төсөл, сангийн зардлыг 4,786.3 сая төгрөгөөр буюу 80.1 хувиар хэмнэсэн нь орон нутгийн төсвийн зарлагыг 8,9 хувиар хэмнэгдэх нөхцөл болсон байна.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨСӨН ҮҮ?

1.1 Аймаг, сумын орлогыг үндэслэлгүйгээр өсгөж төлөвлөсөн байна.

1.1.1 Аймгийн 2016 оны төсвийн орлогыг Төсвийн тухай хуулийн 57 болон 58 дугаар зүйлийн 58.2 -д заасан нөхцөл, чиг үүрэг, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам", аймгийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, холбогдох бусад хууль эрх зүйн актуудыг үндэслэн боловсруулжээ.

1.1.2 Аймгийн ТЕЗ-ийн зүгээс 2016 оны төсвийн төслийг судалгаа, тооцооллын үндсэн дээр бодитоор боловсруулаагүйгээс татварын бодлого, хувь хэмжээ өөрчлөгдөөгүй байхад орон нутгийн төсвийн зарим орлогуудыг үндэслэлгүйгээр өсгөж, тооцоолсон нь жилийн эцэст санхүүжилт танагдах, төсөвт тодотгол хийгдэх эрсдлийг үүсгэсэн байна. Тухайлбал:

- “Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар”-ыг 2015 оны батлагдсан төлөвлөгөөнөөс 15 хувиар, гүйцэтгэлээс 45 хувиар тус тус нэмэгдүүлж 12,081.2 сая төгрөг байхаар,
- 2015 онд улсын тэмдэгтийн хураамжийн орлогод 485.3 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 356.3 сая төгрөг буюу 73,5 хувийн биелэлттэй тайлагнагдсан байхад 2016 онд 443.9 сая төгрөгөөр буюу 2015 оны гүйцэтгэлээс 20.0 хувиар өсгөж төлөвлөсөн байна.

1.1.3 Зарим сумдын 2016 оны төсвийн орлогыг 2015 оны батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэлээс 70,0 - 290,0 хувь буюу бараг 3,0 дахин огцом өсгөж, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг бууруулахаар төлөвлөсөн байна. Тухайлбал:

Баруунбүрэн сумын 2016 оны төсвийн орлогыг 2015 оны батлагдсан төлөвлөгөөнөөс 2,1 дахин, гүйцэтгэлээс 2,4 дахин, Сүхбаатар сумын орлогыг 2015 оны төлөвлөгөөнөөс 82,4 хувиар, Цагааннуур сумын орлогыг 2,9 дахин, гүйцэтгэлээс 2,7 дахин өсгөж төлөвлөжээ.

1.1.4 Аймаг, сумдын орлогыг үндэслэлгүйгээр төлөвлөснөөс шалтгаалан жилийн эцэст Сүхбаатар сумын орлогыг 92.9 сая төгрөгөөр, Цагааннуур сумын орлогыг 14.8 сая төгрөгөөр бууруулан, санхүүгийн дэмжлэгийг өсгөж тодотгосон байна.

1.1.5 Дээрх нөхцөл байдлаас шалтгаалан тайлант онд аймаг, сумдын төсөвт тус бүр 3-4 удаа тодотгол хийгдсэн байна.

1.2. Ард иргэдийн санал аваагүй, зураг төсөвгүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ОНХС, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталдаг зөрчил оршсоор байна.

1.2.1 Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсөвт байгууллагуудын 2016 оны нийт зарлагыг аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 74 дүгээр тогтоолоор **65075,8 сая** төгрөгөөр төлөвлөж, баталсан байна.

1.2.2 Хөрөнгийн зардлыг тооцоолохдоо Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ын 66.1.3 “*их засвар хийхээр бол холбогдох төсвийг зохих норм, норматив, дүрмийн дагуу бэлтгэсэн байх*”, 6.1.4 “*тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж худалдаж авахаар бол өмнө нь ашиглаж байсан хөрөнгө нь зохих элэгдлийн нормд заасны дагуу өртгөө бүрэн нөхсөн, эсвэл зохих журмын дагуу хэрэглээнээс актлагдсан бол орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэлээс хасагдсныг нотолсон байх*” зэрэг заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

1.2.3 Аймгийн урсгал зардлын санхүүжилтийг холбогдох заавар журам, Сангийн яамнаас ирүүлсэн удирдамжийн дагуу төлөвлөсөн хэдий ч ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүд нь Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын холбогдох заалтуудыг зөрчиж, зураг төсөвгүй, ард иргэдийн саналаар баталгаажаагүй, тэвчиж болох төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

1.2.4 Төсвийн тухай хуулийн 60.3.6-д “Орон нутгийн иргэдийн санал аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчин иргэдийн саналаар баталгаажаагүй 29 төсөл, арга хэмжээнд ОНХС-гаас 1391,6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

1.2.5 Зураг, төсөв хийгдээгүй нийт 428.5 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөж, баталсан байна. Үүнд:

- 75.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сант суманд наадмын талбай барих
- 75.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Орхон суманд наадмын талбай барих
- 80 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Түшиг сумын үерийн хамгаалалтын далан барих

- 50 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хушаат сумын цахилгааны шугамын шинэчлэлт
- 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Жавхлант суманд мал эмнэлэг, үржлийн албаны үйлчилгээний цогцолбор барих
- 20.0 сая төгрөгөөр аймгийн итгэмжлэгдсэн лабораторид химийн урвалж бодис авах
- 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сүхбаатар сумын 2-р сургуулийн дээвэр, гадна фасадны засвар
- 34.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сүхбаатар сумын 4-р сургуулийн сантехник засвар
- Бүх сумдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 34 сая төгрөг

1.2.6 ОНХС-гийн хөрөнгөөр Мандал сумын Хэрх тосгоны Захирагчийн албаны барилгын дээврийн засварын ажлыг 80,0 сая төгрөгөөр, Цагааннуур сумын ЗДТГ-ын барилгын засварын ажлыг 8,0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр төлөвлөсөн нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.4-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2.7 2016 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар улсын төсөвт байгууллагуудын урсгал зардал болон хөрөнгө худалдан авах 23.4 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.3 Аймаг болон сумдын төсөвт тайлант онд 2-4 удаа тодотгол хийгдсэн байна.

1.3.1 Аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 74 дүгээр тогтоолоор 2016 оны орон нутгийн нийт орлого, зарлагын төлөвлөгөөг 65,075.8 сая төгрөгөөр буюу төсвийн алдагдалгүйгээр Сангийн яамнаас хянаж, ирүүлсэн дүнгээр төлөвлөж баталсан байна. Орлогын эх үүсвэрийг татварын орлогоос 13,258.9 сая төгрөг, татварын бус орлогоос 594.6 сая төгрөг, хөрөнгийн орлогоор 72.1 сая төгрөг, улсын төсвөөс 1,138.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, ОНХС-гийн орлогын шилжүүлгээр 7,472.6 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр 42,539.4 сая төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

1.3.2 Төсвийн жилийн дундуур аймгийн ИТХ-аас аймгийн төсөвт 3 удаа тодотгол хийсэн байна. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын 2016 оны 03 дугаар сарын 25-ний өдрийн 80 дугаар тогтоолоор 2015 оны жилийн эцсийн үлдэгдэл 686.3 сая төгрөг болон татварын буцаан олголтыг гүйцэтгэлээр нь буюу 244.1 сая төгрөгөөр бууруулан, хөрөнгө оруулалтын зардалд 618.2 сая төгрөг, бусад урсгал зардалд 312.2 сая төгрөгийг зарцуулахаар тодотгосон,
- УИХ-ын 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 47 дугаар тогтоолоор аймгийн суурь орлогыг 2,955.4 сая төгрөгөөр бууруулж, санхүүгийн дэмжлэгийг 2,921.5 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн орлогыг 632.2 сая төгрөгөөр нэмэгдүүлснээс шалтгаалан аймгийн ИТХ-ын 2016 оны 10 дугаар сарын 07-ны

өдрийн 07 дугаар тогтоолоор хувь хүний орлогын албан татварыг 1.402.7 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 2.0 сая төгрөгөөр, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогыг 12.3 сая төгрөгөөр, ус ашигласны төлбөрийн орлогыг 30.1 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлогыг 52.1 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг 37.1 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 2.0 сая төгрөгөөр, ОНХС-гийн орлогын шилжүүлгийг 2.585.2 сая төгрөгөөр тус тус бууруулан, газрын төлбөрийн орлогыг 48.3 сая төгрөгөөр, хувьцааны ногдол ашгийн орлогыг 20.0 сая төгрөгөөр, сумдаас авах орлогын тэгшитгэлээр 204.1 сая төгрөгийг тус тус нэмэгдүүлэн нийт дүнгээр 297.7 сая төгрөгөөр төсвийн орлого, зарлагыг бууруулан тодотгосон,

- Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 15 дугаар тогтоолоор Хүдэр сумын байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө давж биелэснээс аймгийн татварын орлогод 228.1 сая төгрөгийг татан төвлөрүүлэхээр, татварын буцаан олголт 20.9 сая төгрөгөөр хэмнэгдсэнээс шалтгаалан орлого, зарлагыг 249.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна.

1.3.3 Орон нутгийн төсвийн төлөвлөлтийн өөрчлөлтийг хийгдсэн тодотгол тус бүрээр хүснэгтлэн харуулбал:

№	Үзүүлэлт	Сангийн ямны хянасан дүн	Хүснэгт-1 /сая.төг/ 2016 он			
			Анх батлагдсан	Тодотгол- 1	Тодотгол- 2	Тодотгол- 3
А	Б	1	2	3	4	5
	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГО	65075.8	65075.8	66006.2	65504.4	65753.4
	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	65075.8	65075.8	66006.2	65504.4	65753.4
	УРСГАЛ ОРЛОГО	13853.5	13853.5	14097.6	12699.5	12720.4
	Татварын орлого	13258.9	13258.9	13503.0	12066.9	12087.8
	Татварын бус орлого	594.6	594.6	594.6	632.6	632.6
	ХӨРӨНГИЙН ОРЛОГО	72.1	72.1	72.1	-	-
	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	51150.2	51150.2	51150.2	52118.6	52118.6
	Урьд оны үлдэгдэл	0	0	686.3	686.3	686.3
	Сумдаас төвлөрүүлэх орлого	0	0	0	0	228.1
	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ЗАРЛАГА	65075.8	65075.8	66006.2	65504.4	65753.4
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65075.8	65075.8	66006.2	65504.4	65753.4
	УРСГАЛ ЗАРДАЛ	57085.6	57085.6	57305.6	59086.2	59035.2
	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45203.6	45203.6	45423.6	48176.2	48125.2
	ХҮҮ	0.0	0.0	0.0	0.0	0.0
	ТАТААС	641.7	641.7	641.7	651.7	651.7
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11240.3	11240.3	11240.3	10258.3	10258.3
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7990.2	7990.2	8700.6	6418.2	6718.2

ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	0.0	0.0	0.0	0.0
УРСГАЛ ТЭНЦЭЛ	43232.1	43232.1	43208.0	46386.7	46314.8
НИЙТ ТЭНЦЭЛ	0.0	0.0	0	0	0

1.3.4 Орон нутгийн төсөвт хамгийн сүүлд / 2016 оны 12 сарын 02-ны өдөр / хийгдсэн тодотголоор орлого талд дараах өөрчлөлт оруулсан байна. Үүнд:

- Хүдэр сумаас 228.1 сая төгрөгийг орлогыг татан төвлөрүүлэхээр,
- Татварын буцаан олголтын хэмнэлт 20.9 сая төгрөгөөр хувь хүний орлогын албан татварын буцаан олголтын дүнг бууруулахаар ,

Зарлага талд дараах өөрчлөлт хийгдсэн байна. Үүнд:

- Хүдэр сумын санхүүгийн дэмжлэгийг 95.9 сая төгрөгөөр, Ерөө сумын санхүүгийн дэмжлэгийг 92.9 сая төгрөгөөр бууруулах, Сүхбаатар сумын санхүүгийн дэмжлэгийг 116.9 сая төгрөгөөр, Орхон сумын санхүүгийн дэмжлэгийг 6.0 сая төгрөгөөр, Цагааннуур сумын санхүүгийн дэмжлэгийг 14.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэхээр,
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг 300.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр,

1.3.5 Аймаг, сумдын хэмжээнд төсвийн орлогыг үндэслэлгүй төлөвлөснөөс 2016 онд Түшиг сум 4 удаа, Алтанбулаг, Ерөө, Сант, Сайхан, Хүдэр сумд болон аймгийн төсөвт 3 удаа, бусад сумд тус бүр 2 удаагийн тодотгол хийсэн байна.

1.4 Аймгийн төсвийн тэнцлийн алдагдлыг урьд оны үлдэгдэл болон сумдаас төвлөрүүлэх орлогын эх үүсвэрээс нөхөхөөр төлөвлөсөн байна.

1.4.1 2016 онд аймгийн төсөвт 3 удаа, сумдын төсөвт тус бүр 2-4 удаа тодотгол хийн, орон нутгийн төсвийн зарлагыг өсгөсөн бөгөөд түүнийг нөхөх эх үүсвэрийг аймаг, сумдын ерөнхий орлогын дансны оны эхний үлдэгдэл 1,900.4 сая төгрөг болон сумаас төвлөрүүлэх 228.1 сая төгрөгийн орлогоор нөхөхөөр төлөвлөсөн байна.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛСЭН ҮҮ?

2.1 Аймгийн төсвийн татварын ба татварын бус орлогын төлөвлөгөөг 107.6 хувиар биелүүлсэн байна.

2.1.1 Аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 74 дүгээр тогтоолоор 2016 онд аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 13,853.6 сая төгрөгөөр баталсан бол тайлант онд 3 удаа тодотгол хийж, 12,637.8 сая төгрөгөөр буюу анхны баталсан дүнгээс 1,215.8 сая төгрөгөөр бууруулж эцэслэн баталсан байна.

2.1.2 Сумдын ИТХ-аас татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг 4,265.3 сая төгрөгөөр тодотгон баталснаар Сэлэнгэ аймгийн 2016 оны урсгал орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 16,903.1 сая төгрөгөөр батлагдсан байна.

2.1.5 Гүйцэтгэлээр аймгийн орлого 18,196.1 сая төгрөгийн, сумдын орлого 5,312.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, нийт дүнгээр 107.6 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Татварын болон татварын бус орлогын гүйцэтгэлийг харуулбал:

Хүснэгт 2 (сая төгрөг)

Орлогын нэр төрөл	Өмнөх он	Тайлант оны гүйцэтгэл							
		Аймгийн орлого		Сумдын орлого		Төсвийн нийт орлого			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын болон татварын бус орлого	14,386.2	12,637.8	12,883.5	4,265.3	5,312.6	16,903.1	18,196.1	1,292.9	107.6
Татварын орлого	13,209.2	12,107.8	12,413.1	3,373.5	4,276.4	15,481.3	16,689.5	1,208.2	107.8
Хүн амын орлогын албан татвар	9,006.8	9,451.1	9,796.6	743.3	765.3	10,194.4	10,561.9	367.5	103.6
Өмчийн татвар	796.7	868.3	978.2	0.0	0.0	868.3	978.2	109.9	112.7
Бараа үйлчилгээний албан татвар	3,405.7	1,788.4	1,638.3	2,630.2	3,511.1	4,418.6	5,149.4	730.8	116.5
Татварын бус орлого	1,177.0	530.0	470.4	891.8	1,036.2	1,421.8	1,506.6	84.7	106.0
Өмчийн орлого	7.4			4.3	3.2	4.3	3.0	-1.3	72.9
Торгууль,шимтгэл	651.9	220.0	162.6	525.3	729.6	745.3	892.4	147.1	119.7
Татварын бус бусад орлого	517.7	310.0	307.8	362.2	303.4	672.2	611.2	-61.1	90.9
НИЙТ ОРЛОГЫН ДҮН	14,386.2	12,637.8	12,883.5	4,265.3	5,312.6	16,903.1	18,196.1	1,292.9	107.6

2.1.6 Хүснэгтээс үзэхэд хүн амын орлогын албан татвар 367.5 сая төгрөгөөр, өмчийн татвар 109.9 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний албан татвар 730.8 сая төгрөгөөр татварын бус орлого 84.8 сая төгрөгөөр тус тус давж биелэсэн байна.

2.1.7 Хэдийгээр нийт дүнгээр орлогын төлөвлөгөө давсан боловч 6 сумын орлогын төлөвлөгөө 0.4- 23.2 сая төгрөгийн хооронд буюу нийт 56.9 сая төгрөгөөр тасарч, 11 сумын орлогын төлөвлөгөө 1.8 - 497.2 сая төгрөгөөр давж биелэсэн байна.

Төсвийн орлогын гүйцэтгэлийг төсвийн захирагчдаар харуулбал:

Хүснэгт 3 (сая төгрөг)

д/д	Сумдын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Алтанбулаг	371.4	409.2	37.8	110.2
2	Баруунбүрэн	88.8	100.2	11.4	112.9
3	Баянгол	116.3	120.0	3.7	103.2
4	Ерөө	590.7	725.2	134.5	122.8
5	Хүдэр	917.8	1,259.4	341.6	137.2
6	Хушаат	44.9	29.4	(15.5)	65.4

хуудас 9

7	Жавхлант	28.6	35.5	6.9	124.4
8	Мандал	889.3	1,386.7	497.4	155.9
9	Орхон	51.7	48.4	(3.3)	93.7
10	Орхонтуул	86.4	73.2	(13.2)	84.7
11	Сайхан	323.7	365.4	41.7	112.9
12	Сант	51.5	50.2	(1.3)	97.5
13	Шаамар	72.8	95.5	22.7	131.2
14	Сүхбаатар	372.1	348.9	(23.2)	93.8
15	Цагааннуур	82.5	84.3	1.8	102.2
16	Түшиг	144.4	149.1	4.7	103.2
17	Зүүнбүрэн	32.4	32.0	(0.4)	98.8
	Сумдын дүн	4,265.3	5,312.6	1,047.3	124.6
18	Аймгийн орлого	12,637.8	12,883.5	245.7	101.9
	Нийт дүн	16,903.1	18,196.1	1,293.00	107.6

2.1.8 Аймгийн татварын ба татварын бус орлого нийт дүнгээр биелэсэн боловч нэр төрлөөр нь авч үзэхэд улсын тэмдэгтийн хураамж 216.0 сая төгрөгөөр, хүү торгууль, ангилагдаагүй орлого 59.5 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Аймгийн орлого тасарсан шалтгааныг авч үзвэл:

- *Улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийн дунджаар тооцож ирсэн бөгөөд ИХШХГазрын визийн улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг аймгийн төсөвт төвлөрүүлэн зарцуулдаг байсныг аймгийн Аудитын газраас өгсөн албан шаардлагын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх болсноос шалтгаалжээ.*

2.1.9 Сумдын орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзэхэд улсын тэмдэгтийн хураамж 61.7 сая төгрөгөөр, хөрөнгийн хөдлөл, эрхийн орлого 44.4 сая төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөр 17.2 сая төгрөгөөр, хог хаягдлын хураамжийн орлого 15.7 сая төгрөгөөр, бууны албан татвар 6.4 сая төгрөгөөр, түрээсийн орлого 1.2 сая төгрөгөөр, бусад орлого 1.3 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Сумдын орлого тасарсан шалтгааныг авч үзэхэд:

- *Хөрөнгийн хөдлөл, эрхийн орлогыг Сүхбаатар сум 13.6 сая төгрөг, Сайхан сум 12.0 сая төгрөг, Мандал сум 8.0 сая төгрөгөөр тасалсан бөгөөд энэ нь иргэдийн худалдан авах чадвар муудаж, үл хөдлөх хөрөнгө борлуулалт буурснаас шалтгаалсан байна.*
- *Улсын тэмдэгтийн хураамжийг Алтанбулаг сум 37.5 сая төгрөг, Мандал сум 9.4 сая төгрөг, Сүхбаатар сум 5.3 сая төгрөг, Орхон сум 3.8 сая төгрөг, Цагааннуур сум 2.1 сая төгрөгөөр тасалсан байна. Уг орлогыг сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийн дунджаар тооцож ирсэн бөгөөд Алтанбулаг сум нь ИХШХГазрын визийн улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг сумын төсөвт*


төвлөрүүлэн зарцуулдаг байсныг улсын төсөвт төвлөрүүлэх болсноос шалтгаалжээ.

- Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг Мандал сум 23.0 сая төгрөг, Хүдэр сум 20.3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн бол Түшиг сум 23.2 сая төгрөг, Хушаат сум 21.9 сая төгрөг, Ерөө, Баруунбүрэн сумд 18.0 сая төгрөгөөр тасалсан байна. Жил бүр аймгийн ИТХ-ын тогтоолоор үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод, түлээ бэлтгэх хуваарийг баталж, үүнд үндэслэн төлөвлөлтийг тооцдог боловч сүүлийн 2 жил дараалан төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйгээс шалтгаалсан байна.
- Хог хаягдлын хураамжийн орлогыг Сайхан сум 17.4 сая төгрөг, Сүхбаатар сум 9.9 сая төгрөг, Мандал сум 9.5 сая төгрөгөөр тасалсан бөгөөд иргэдээс авах төлбөр хураамжийг бүрэн төвлөрүүлээгүйгээс шалтгаалжээ.

2.2 Орон нутгийн төсвийн байгууллагууд өөрийн орлогыг нэмж төлөвлөх нөөц боломж байна.

2.2.1 Орон нутгийн төсөвт байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөөг 110.2 хувиар буюу 22.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөөг 10.5 хувиар буюу 10.5 сая төгрөгөөр тасалсан байна.

Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг графикаар харуулбал:



2.2.2 Орон нутгийн байгууллагуудаас Ерөө сумын Ойн анги 6.1 сая төгрөг, Сүхбаатар сумын ЗДТГ 4.7 сая төгрөг, Түшиг сумын ЗДТГ 3.4 сая төгрөг, Шаамар сумын Дулаанхаан тосгоны Захирагчийн алба 3.2 сая төгрөг, Баянгол сумын ЗДТГ 1.9 сая төгрөг, Мандал сумын Ойн анги 1.6 сая төгрөг, Жавхлант сумын ЗДТГ 1.1 сая төгрөг, Орхон сумын ЗДТГ 0.8 сая төгрөгөөр тус тус өөрийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 1-д үзүүлэв. /

2.2.3 Дээрх байгууллагуудаас Түшиг сумын ЗДТГ болон Дулаанхаан тосгоны Захирагчийн алба нь нийт 6.6 сая төгрөгийн түрээсийн орлогыг төлөвлөж, батлуулаагүй байгаа бөгөөд цаашид өөрийн орлогыг бодит байдалд нийцүүлэн төлөвлөж, нэмэгдүүлэх боломжтой байна.

2.2.4 Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудаас аймгийн Биеийн тамир спортын хороо 2.9 сая төгрөг, Мандал сумын Хэрх тосгоны Соёлын төв 1.5 сая төгрөг, аймгийн музей 0.5 сая төгрөгөөр тус тус өөрийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 2-т үзүүлэв. /

2.2.5 Дээрх байгууллагуудаас аймгийн Биеийн тамир спортын хороо нь 2016 оноос Мобиком корпорацийн антенн байршуулсны түрээсийн орлого 1.8 сая төгрөг, Мандал сумын Хэрх тосгоны Соёлын төв 1.5 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлж байгаа бөгөөд уг дүнгээр өөрийн орлогыг нэмж төлөвлөх нөөц боломж оршиж байна.

2.2.6 Өөрийн орлогын төлөвлөгөөг ихэвчлэн урлаг, соёлын байгууллагууд тасалсан байгаа бөгөөд Сэлэнгийн долгио чуулга, сумдын соёлын төвүүд нь иргэдийн дунд соёлын арга хэмжээг өргөн хүрээтэй явуулах, соёл урлагийн бусад байгууллагуудтай хамтран ажиллах, байр түрээслүүлэх замаар өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх бүрэн боломжтой байна.

2.3 Орон нутгийн төсөвт төвлөрөх орлогыг холбогдох хууль, эрхийн актуудад нийцүүлэн бүрэн төвлөрүүлээгүй байна.

2.3.1 Аудитаар, төсвийн орлогын төлөвлөгөөг тасалсан, аймгийн төсөвт төвлөрөх орлогыг сумын төсөвт төвлөрүүлсэн, татварын орлогыг касст бэлнээр авч зарцуулсан зэрэг алдаа, зөрчил илэрлээ. Үүнийг тодруулбал:

- *Мандал сум төсвийн орлого болох самрын зөвшөөрлийн хураамж 80.0 сая төгрөгийг ЗДТГ-ын касст бэлнээр орлого авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 35.3-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ” , Сангийн сайдын 2012 оны 276 тоот тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6-д "Үндсэн болон туслах үйл ажиллагаанаас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг ажлын дараагтын өдөрт багтаан кассын нярав төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.*
- *Орхонтуул сум хадлангийн газрын төлбөрийн 16.2 сая төгрөгийн орлогыг аймгийн төсөвт бус сумын төсөвт төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 23.7 “Аймаг, нийслэлийн төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ: 23.6.2. газрын төлбөр”, Газрын тухай хуулийн 11-р зүйлийн 11.1. “Хөдөө аж ахуйн газарт бэлчээр, хадлан, тариалан, атаршсан газар, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулсан бусад газар хамаарна”, Газрын төлбөрийн тухай хуулийн 4-р зүйлд “Газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээний дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа, Газрын тухай хуулийн 10 дугаар*

зүйлд заасан газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд хамаарах болон тусгай хэрэгцээний газарт төлбөр ногдуулна” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.3.2 Сумдууд төсвийн орлогын төлөвлөгөөг, орон нутгийн төсөвт байгууллагууд өөрийн орлогын батлагдсан төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 41.2.1-дэхь “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнийг тодруулбал:

- *Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг Сүхбаатар сум 23.2 сая төгрөгөөр, Хушаат сум 15.5 сая төгрөгөөр, Орхонтуул сум 13.2 сая төгрөгөөр, Сант сум 1.3 сая төгрөгөөр, Зүүнбүрэн сум 0.4 сая төгрөгөөр буюу нийт 53.6 сая төгрөгөөр тус тус тасалжээ. Эдгээрээс Сүхбаатар, Орхонтуул, Хушаат сумдууд төсвийн орлогын төлөвлөгөөг 2 дахь жилээ тасалсан бөгөөд энэ нь орлогын төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлээс хэт өндрөөр төлөвлөсөнтэй холбоотой байна.*
- *Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг Баруунбүрэн сумын сум дундын Ойн анги 5.9 сая төгрөг, Цагааннуур сумын Спорт цогцолбор 2.6 сая төгрөг, Ойн анги 1.3 сая төгрөг, Орхонтуул сумын Соёлын төв 1.3 сая төгрөг, Орхон сумын Соёлын төв 1.0 сая төгрөг, Баянгол сумын Соёлын төв 0.4 сая төгрөг, Сант сумын Соёлын төв 0.3 сая төгрөг, Сайхан сумын ЗДТГ 0.3 сая төгрөг, Номгон тосгоны Соёлын төв 0.1 сая төгрөг зэрэг нийт 13,2 сая төгрөгөөр тасалжээ. Эдгээрээс Баруунбүрэн сумын сум дундын Ойн анги өөрийн орлогын төлөвлөгөөг 2 дахь жилээ тасалсныг авч үзвэл гүйцэтгэл өмнөх оноос 2.3 сая төгрөгөөр давж биелэсэн боловч орлогыг хэт өндөр төлөвлөсөнтэй холбоотой байна.*

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ БОДИТОЙ БАЙНА УУ

3.1 Төсвийн нийт зарлагын хэмнэлтийн 80.6 хувийг хөрөнгө оруулалт, төсөл, сангийн зарлагын хэмнэлт эзэлж байна.

3.1.1 Сэлэнгэ аймгийн 2016 оны төсвийн нийт зарлага тодотгосон төсвөөр 77,218.4 сая төгрөгөөр батлагдснаас 70,348.4 сая төгрөгийг зарцуулж, 91.1 хувийн гүйцэтгэлтэй буюу 6,870.0 сая төгрөгийн хэмнэлттэй тайлагнагдсан байна. Энэ нь өмнөх оны зарлагын гүйцэтгэлээс 2.3 хувиар өссөн байна. Төсвийн нийт зарлагын 38.1 хувийг орон нутгийн төсөвт байгууллагуудын зарлага, 61.9 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардал эзэлж байна. Нийт зарлагыг эдийн засгийн ангиллаар харуулбал:

Хүснэгт 4 /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	68,743.9	77,218.4	70,348.4	(6,870.0)
УРСГАЛ ЗАРДАЛ	66,097.3	74,965.6	69,771.8	(5,193.8)
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	49,721.0	53,598.6	52,051.9	(1,546.7)
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	31,781.0	32,847.8	32,619.6	(228.2)

Ажил олгогчоос нийгмийн даатгалд телэх шимтгэл	3,466.6	3,612.8	3,575.8	(37.0)
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,981.3	7,398.4	7,205.6	(192.8)
Хангамж, бараа материалын зардал	971.4	1,256.6	1,222.0	(34.6)
Нормативт зардал	2,585.5	3,015.2	2,958.1	(57.1)
Эд хогшил, урсгал засварын зардал	501.9	666.7	641.5	(25.2)
Томилолт, зочны зардал	225.9	211.8	203.8	(8.0)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, ййлчилгээний телбер, хураамж	848.2	1,288.1	1,281.6	(6.5)
Бараа үйлчилгээний бусад зардал	3,359.1	3,301.1	2,344.0	(957.1)
ХҮҮ	-	2,687.2	351.5	(2,335.7)
ТАТААС	434.0	572.2	572.2	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	680.7	111.0	197.5	86.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,326.1	7,495.0	6,159.3	(1,335.7)

3.1.2 2016 онд орон нутгийн төсвийн нийт зардал 27,971.0 сая төгрөгөөр батлагдснаас 26,320.0 сая төгрөг буюу 94.1 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан бөгөөд нийт зардлын 75.3 хувийг урсгал зардал, 24.7 хувийг хөрөнгө оруулалтын зардал эзэлж байна.

3.1.3 Төсөл сангийн нийт зардал 5,976.2 сая төгрөгөөр батлагдаж, эх үүсвэрээс шалтгаалан гүйцэтгэлээр 1,190.4 сая төгрөг буюу 19.9 хувьтай тайлагнагдсан байна.

3.1.4 2016 онд тусгай зориулалтын байгууллагуудын төсвийн нийт зарлага 43,271.2 сая төгрөгөөр батлагдснаас 42,838.0 сая төгрөг буюу 98.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зарлагын 85.9 хувийг БСШУСайдын, 12.8 хувийг ЭМСайдын, 0.6 хувийг БХБСайдын, 0.7 хувийг ХАХНХСайдын багцын байгууллагуудын зарлагын гүйцэтгэл эзэлж байна.

Нийт зардлын гүйцэтгэлийг графикаар харуулбал /хувиар/:

График-2



3.1.5 Нийт төсвийн зарлагын 68,0 хувийг цалин, шимтгэлийн зардал, 6.9 хувийг нормативт зардалд, 5.7 хувийг бусад урсгал шилжүүлгийн зардалд, 14.3 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 5.1 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

3.1.6 Төсвийн нийт зарлагын хэмнэлтэд орон нутгийн болон ОНХС-гийн хөрөнгө оруулалт, төсөл сангийн зарлага, бусад бараа үйлчилгээний зардлын хэмнэлт нөлөөлсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хүснэгт 5 /сая төгрөг/ хэмнэлт/-/,хэтрэлт/+/
1.Орон нутаг	27,970.9	26320.0	-1,650.9
үүнээс:Хөрөнгө оруулалт	955.5	738.4	-217.1
ОНХС	5,331.2	4,794.6	-536.6
Бусад			-897.2
2.Бусад төсөл сан	5,976.2	1,190.4	-4,786.3
3.Тусгай шилжүүлэг	43,271.2	42,838.0	-433.2
НИЙТ	77,218.4	70,348.4	-6,870.0

3.2 Аймаг хөгжүүлэх болон сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн 90.2 хувь нь хугацаа хэтэрсэн байна.

3.2.1 2016 онд Сэлэнгэ аймгийн ОНХС-д оны эхний үлдэгдлээс 92.3 сая төгрөгийн, улсын төсвөөс 4,887.3 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, нийт 4,979.6 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн, 58 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнээс эх үүсвэр бүрэн төвлөрч, 45.5 хувийг буюу 2,223.6 сая төгрөгийг аймгийн, 54.5 хувийг буюу 2,663.8 сая төгрөгийг сумдад олгохоор хуваарилан баталснаас сумдын ОНХС-гийн санхүүжилт 2 хувиар буюу 41.2 сая төгрөгөөр дутуу олгогдсон байна.

3.2.2 Аудитаар иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн, төсөвт өртгийг хувааж тендер зарласан, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, техник хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлээгүй, комиссын актаар төсөл, хөтөлбөрийг хүлээн аваагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн ажлыг хөрөнгийн орлогоор бүртгээгүй зэрэг нийт 342.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрлээ.Тухайлбал:

- Сүхбаатар сумын ИТХ-аар баталсан ОНХС-гийн 2016 оны төлөвлөгөөнд Хонгор морьт 1-р багт 25ш, Салхит 3-р багт 11 ш, Бор гүвээ 5-р багт 14 ш, Ган зам 7-р багт 11ш гэрэлтүүлэг хийлгэх ажил нийт 76,4 сая төгрөгийн төсөвт өртгөөр батлагдсан байхад ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа төсөвт өртгийг нь хувааж, 2 гүйцэтгэгчийг шалгаруулсан,
- Зүүнбүрэн сумын ИТХ-ын 2016 оны 08 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар “Хогийн цэг, гэрэлтүүлгийн арчлалт хамгаалалт, ногооны техник тоног төхөөрөмж” гэсэн багцаар 18.8 сая төгрөг баталсан боловч гүйцэтгэлээр “Зүүнбүрэн хаалганы засвар, шинэчлэл”-ийн зардалд 10.0 сая төгрөг, ХАА-н техникийн сэлбэг 1,4 сая төгрөг, бусад 4 төрлийн ажилд 1.1 сая төгрөг зэргээр хэд хэд хувааж гүйцэтгэгчийг шалгаруулсан,
- Орхон сум аймгийн ОНХС-гаас эрх шилжүүлсэн 75.0 төгрөгийн төсөвт өртөг бүхий “Наадмын талбай барих ажил”-ын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар

сонгохдоо эрх бүхий этгээдэд үнийн санал ирүүлэхийг албан ёсоор мэдэгдээгүй бөгөөд барилгын ажил эрхлэх “Тусгай зөвшөөрөл”-ийн хугацаа дуусч, Барилгын хөгжлийн төвийн тодорхойлолт ирүүлсэн Самосон ХХК-ийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан,

- Иргэдийн санал аваагүй нийт 48.1 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд; Алтанбулаг сум 10.0 сая төгрөгийн, Орхон сум 9.9 сая төгрөгийн, Орхонтуул сум 18.9 сая төгрөгийн, Сант сум 4.6 сая төгрөгийн, Түшиг сум 4.7 сая төгрөг.
- Ерөө сумын ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 8.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Бугант тосгоны нийтийн орон сууцны цахилгааны засвар”, 6.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Гудамжны камер суурилуулах”, 5,6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Wi-Fi суурилуулах” зэрэг ажлуудыг комиссын актаар ашиглалтад хүлээн аваагүй байхад үлдэгдэл санхүүжилт 7.0 сая төгрөгийг олгосон,
- Хушаат сум ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан 18.8 сая төгрөгийн өртөг бүхий паркалсан хүлэмжийг хөрөнгийн дансанд бүртгэлд тусгаагүй байна.

3.2.3 Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 15 дугаар “Сэлэнгэ аймгийн 2016 оны тодотгосон төсөв батлах тухай” тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр урьд оноос шилжих 7 төсөл, арга хэмжээнд 395.6 сая төгрөг, шинээр эхлэх 29 төсөл арга хэмжээнд 658.7 сая төгрөг, нийт 1,054.2 сая төгрөгийг баталсан байна.

3.2.4 Өмнөх оноос шилжиж ирсэн 7 төсөл арга хэмжээний санхүүжилтэд 382.8 сая төгрөгийг, шинээр эхлүүлсэн 14 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 339.0 сая төгрөгийг зарцуулж, аймгийн төрийн санд байрших орон нутгийн хөрөнгө оруулалтын барьцааны дансанд 16.6 сая төгрөгийг шилжүүлэн, 721.8 сая төгрөг буюу 68.5 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

3.2.5 Төсвийн тухай хуулийн 4.1.24 дэх “Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ”, 6.6.6 дахь “Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалтуудыг зөрчин улсын төсвийн байгууллагуудын урсгал зардал болон хөрөнгө худалдан авахад 19.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

- Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын лабораторид химийн урвалж бодис худалдан авахад 6.0 сая төгрөг,
- Хил хамгаалах туслах хүчний зөвлөлд сансрын холбооны антен худалдан авахад 5.0 сая төгрөг,
- Аймгийн Прокурорын газарт тавилга худалдан авахад 8.9 сая төгрөг.

3.2.6 Аймгийн замын сангийн хөрөнгөөр ажлын нэр төрөл, газар зүйн байрлалын хувьд нэг төрлийн болон ижил цаг хугацаанд тендер зарласан 79.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Аймгийн нэгдсэн эмнэлгээс 1 дүгээр сурууль хүртэлх хайрган хучилттай зам болон зогсоол барих”, 80.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Сүхбаатар сумын 4

дүгээр багт хайрган хучилттай зам тавих” ажлуудыг нэг багц болгож сонгон шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй байхад санхүүжилтийг олгосон байна.

3.2.7 Төсөл, сангийн зарцуулалттай холбоотой, зардлын бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан, сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хүүг дутуу хуримтлуулан тооцсон, гэрээг нотариатаар батлуулалгүйгээр зээл олгосон зэрэг нийт 267.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

- *Аймгийн хөгжлийн сангийн эргэж төлөгдөх зээлийн зардлаас аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр хэвлүүлэх болон баяр наадмын зардалд 43.8 сая төгрөг, гадаад томилолтын зардалд 7.7 сая төгрөг зэрэг нийт 51.5 сая төгрөгийн зориулалт бус зардлыг гүйлгэн зарцуулсан боловч гүйцэтгэлийг санхүүгийн тайланд бодитоор тайлагнаагүй,*
- *Аймгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайланд 0.2 сая төгрөгийн зээлийн хүүгийн авлагыг дутуу тусгасан байна,*
- *Сүхбаатар сум хөгжүүлэх сангаас 2016 онд нийт 29 иргэнд зээл олгосноос 11 зээлдэгчийн 104.5 сая төгрөгийн зээлийн гэрээг нотариатаар батлуулалгүйгээр 77.0 сая төгрөгийн зээл олгосон, зээлдэгчийн барьцааны гэрээнд тусгагдсан үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг хувийн хэрэгт хавсаргаагүй байхад санхүүжүүлсэн,*
- *Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн 2016 оны хүүг дутуу хуримтлуулан бүртгэснээс санхүүгийн тайланд 5 сум 105.6 сая төгрөгийн хүүгийн орлогыг дутуу тусгасан байна.*

3.2.8 2016 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 2011-2015 оны хооронд Сум хөгжүүлэх сангаас иргэн, аж ахуйн нэгжид олгосон зээлийн хугацаа хэтрэлт 2,872.1 сая төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 1,105.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.2.9 Аймаг хөгжүүлэх сангаас / ЖДҮ-ийг дэмжих сан/ 2009-2015 оны хооронд олгосон зээлийн хугацаа хэтрэлт 4,008.9 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 1,021.4 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд 2016 онд аймгийн Аудитын газраас хийсэн “ Аймаг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зээлийн хугацаа хэтрэлт нэмэгдсэн байна.

3.3 Төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах талаар УИХ-аас гаргасан тогтоолыг зөрчсөн байна.

3.3.1 УИХ-ын 2016 оны 09-р сарын 09-ний өдрийн 47 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн (в) 3 дахь “тавилга шинээр худалдан авахгүй байх”, 4 дэх “эмнэлэг, цэцэрлэг, сургуульд зайлшгүй урсгал засвар хийхээс бусад тохиолдолд төсвийн байгууллагын албан контор, ажлын байранд урсгал засвар хийхгүй байх”, 6 дахь “төсвийн хөрөнгөөр автомашин шинээр худалдан авахгүй байх” гэсэн заалтуудыг зөрчин шинээр үндсэн хөрөнгө худалдан авахад 26.8 сая төгрөгийг, албан ажлын өрөөнд урсгал засвар хийхэд 10.4 сая төгрөгийг, шинэ жилийн арга хэмжээнд 2.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Үүнд:

- Алтанбулаг сумын ЗДТГ сумын Цагдаагийн албанд 14.6 сая төгрөгөөр Toyota Prius маркийн автомашин худалдан авсан,
- Шаамар сумын ЗДТГ нь сумын Цагдаагийн албанд Toyota Prius маркийн автомашин худалдан авахад 5.0 сая төгрөг зарцуулсан,
- Сайхан сумын ЗДТГ 3.4 сая төгрөгийн үнэ бүхий ширээ, сандал худалдан авсан,
- Хушаат сумын ЗДТГ нь 3.8 сая төгрөгөөр тавилга худалдан авсан,
- Ерөө сумын ЗДТГ нь 6.5 сая төгрөгийг, сум дундын ойн анги нь 0.5 сая төгрөгийн зардлыг урсгал засвар хийхэд зарцуулсан,
- Баянгол сумын ИТХ ажлын албаны конторын хана нураах, засварын ажилд 1.8 сая төгрөгийг зарцуулсан,
- Цагааннуур сумын спорт цогцолбор ажлын байрны урсгал засварт 1.6 сая төгрөгийн зардал гаргасан байна.

3.4 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын 53.4 хувийг орон нутгийн байгууллагууд, 46.6 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардал эзэлж байна.

3.4.1 Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн харилцах дансны эхний үлдэгдэл 940 төгрөг байсан бол 2,412.0 сая төгрөгийн орлого төвлөрч, 2,137.0 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулан 275.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж, оны эцэст харилцахын үлдэлгүй тайлагнагдсан байна. Нэмэлт санхүүжилтийн орлого дараах эх үүсвэрүүдээс бүрдсэн байна. Үүнд:

- Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 1,231.1 сая төгрөг;
- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаар 97.8 сая төгрөг;
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 501.3 сая төгрөг;
- ЗГ-ын болон Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгө болон бусад эх үүсвэрээс 581.8 сая төгрөг тус тус төвлөрсөн байна.

3.4.2 Тайлант онд нэмэлт төсвийн гүйцэтгэлээр 2,412.0 сая төгрөгийг зарцуулсан ба үүнээс нийт зарлагын 77.6 хувь буюу 1,872.2 сая төгрөгийг урсгал зардалд, 10.9 хувь буюу 264.8 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулж, 11.5 хувь буюу 275.0 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтыг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6 /сая.төгрөг/

Зардлын зүйл	Орон нутгийн байгууллага	ТЗШБайгууллага	Нийт зардал
Цалин, НДШ	85.6	20.7	106.3
Эд хогшил худалдан авах болон урсгал засварын	29.6	71.1	100.7

Нэг удаагийн болон ХОНТС, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж, шагнал, урамшууллын	32.8	171.0	203.8
Бусад бараа үйлчилгээний зардал	667.1	835.5	1502.6
Хөрөнгийн зардал	223.6		223.6
Төвлөрүүлэх шилжүүлэг	249.7	25.3	275.0
Нийт дүн	1,288.4	1,123.6	2,412.0

Илрүүлсэн зөрчил

Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:

- Орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлагатай холбоотой 2,195.5 сая төгрөгийн;
- Тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн гүйцэтгэлтэй холбоотой 1,800.3 сая төгрөгийн;
- Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалттай холбоотой 150.6 сая төгрөгийн;
- Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалттай холбоотой 342.6 сая төгрөгийн зэрэг нийт 4,489.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн болно.

Эдгээр зөрчилд Сэлэнгэ аймгийн ТЭЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 51.1 сая төгрөгийн төлбөрийн акт, 1,142.0 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 3,294.8 сая төгрөгийн алдаа, зөрчлийн давтан гаргахгүй ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Аудитын дүгнэлт

- Аймаг,сумын төсвийн орлогыг үндэслэлгүйгээр өсгөж, төлөвлөсөн байна.
- Төсөвт өртгийг урьдчилан тооцоогүй, ТЭЗҮ, зураг төсөв нь хийгдээгүй төсөл, арга хэмжээг орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган, хэрэгжүүлж байна.
- Иргэдийн саналаар баталгаажаагүй, зураг, төсөв нь хийгдээгүй төсөл, арга хэмжээг ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөн, хэрэгжүүлж байна.
- Төсвийн орлогыг бодитой төлөвлөөгүйгээс тайлант онд 2-4 удаа тодотгол хийгдсэн байна.
- Аймгийн төсвийн тэнцлийн алдагдлыг урьд оны үлдэгдэл болон сумдаас төвлөрүүлэх орлогын эх үүсвэрээс нөхөхөөр төлөвлөсөн байна.

- Аймгийн төсвийн татварын ба татварын бус орлогын төлөвлөгөөг 107.6 хувиар биелүүлсэн байна.
- Орон нутгийн төсөвт төвлөрөх орлогыг холбогдох хууль, эрхийн актуудад нийцүүлэн бүрэн төвлөрүүлээгүй байна.
- Орон нутгийн төсвийн байгууллагууд өөрийн орлогыг нэмж төлөвлөх нөөц боломжтой байна.
- Төсвийн нийт зарлагын хэмнэлтийн 80.6 хувийг хөрөнгө оруулалт, төсөл сангийн зарлагын хэмнэлт эзэлж байна.
- Аймаг хөгжүүлэх болон сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн 90.2 хувь нь эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн байна.
- Төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах талаар УИХ-аас гаргасан тогтоолыг зөрчсөн байна.
- Төсвийн тухай хууль, төсвийн зарцуулалттай холбоотой бусад хууль эрхийн актуудыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс төсвийн зарцуулалттай холбоотой зөрчил оршсоор байна.

Аудитын зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

**Аймгийн ТЕЗ, Засаг дарга Ш.Оргил,
ЗДТГ-ын СТСХ-ийн дарга М.Нарантуяа нарт:**

- Орон нутгийн төсвийн орлого, байгууллагуудын үйл ажиллагааны орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж, биелэлтэд тавих хяналтыг сайжруулах.
- Төсөл, сангийн зардлын эх үүсвэрийг төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгон төлөвлөж байх.
- Зураг төсөвгүй, техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалт болон ОНХС-гийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлэхгүй байх.
- Улсын төсөвт байгууллагуудын урсгал болон хөрөнгө худалдан авах зардал, нэн тэргүүний ач холбогдолгүй автомашин, техник тоног төхөөрөмж бэлтгэх, хөшөө дурсгал босгох зэрэг төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй байх.
- Төсвийн тухай хуулийн 23-р зүйлийн дагуу улс, аймаг, сумын төсвийн орлогыг бүрдүүлж, аймгийн төсвийн орлогыг суманд төвлөрүүлэн зарцуулж буй болон төсвийн орлогыг бэлнээр авч зарцуулж буй зөрчлийг таслан зогсоох,

- Төсвийн захирагч нарыг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж, орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарцуулалтад оршиж буй зөрчлийг арилгах.
- Аймаг хөгжүүлэх болон сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийг барагдуулах ажлыг эрчимжүүлэх.
- Батлагдсан төсвийг зохистой удирдаж өр, авлага үүсгэхгүй байх нөхцлийг бүрдүүлэх, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахдаа холбогдох газраас зөвшөөрөл авч, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаж байхыг холбогдох төсвийн захирагч нарт үүрэг болгох.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
ШИНЖЭЭЧ

Ч.ЭНХТУЯА
Б.БАТМӨНХ
Б.НАРАНЧИМЭГ
Ц.ОТГОНБАЯР
С.БААСАНСҮРЭН